

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН 2020

АГУУЛГА

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 7

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 8

ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА БА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД 15

АЖЛЫН БАЙР 25

БАЙГАЛЬ ОРЧИН 31

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ 39

ШАГНАЛУУД 42

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно

ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:

Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.

Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:

Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.

Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг хөгжүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

2009 оны 4-р сард Ухаа худаг уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш

**\$4.0 ТЭРБУМ
ЭКСПОРТ**

**₮1.2 ИХ НАЯД
ТАТВАР**



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг.

Өнөөдрийн байдлаар шууд ба шууд бусаар нийт 4,000 орчим хүнийг ажлын байраар хангадаг, үндэсний 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй тууштай хамтран ажиллаж ирсэн, татвар төлөлт, нийгмийн хариуцлагаар Монгол Улсын ТОП 5 компанийн жагсаалтанд сүүлийн арваад жил тасралтгүй бичигдэж байгаа, уул уурхайн дотоодын тэргүүлэгч аж ахуйн нэгж билээ.

Бид 2009 оноос Ухаа худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Алслагдсан говь нутагт маш богино хугацаанд монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, 650 айлын орон сууцны хороолол, 1,000 гаруй хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэгийн цогцолбор зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулан, дэлхийн жишигт нийцсэн, уул уурхайн цогцолборыг бий болгосон.

2010 оны 10-р сард Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Нээлттэй хувьцаат компани гэдэг утгаараа компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ыг анхнаас нь бодитой, зөв хэрэгжүүлэхэд анхаарч бодлого чиглэлээ олон улсын КНХ-ын сайн дурын стандарт болох ISO: 26000-д нийцүүлэн боловсруулсан. Нийгмийн хариуцлага, байгаль орчин, нөхөн сэргээлтийн бодлого болон орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах бидний хувь нэмэр компанийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй салшгүй холбоотой байдаг.

\$1.4
тэрбум

Уурхай, дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт (2009-2020)

Өнгөрсөн хугацаанд компани нийт нэг 1.4 тэрбум орчим долларыг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 1.2 их наяд орчим төгрөгийг төвлөрүүлжээ.

Энержи Ресурс компани нь нэмүү өртөг шингэсэн, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөн, Монгол

Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилтэд бодитой хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бодлого, баримтлах зарчим

Энержи Ресурс компанийн хувьд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Бид КНХ-ын хүрээн дэх бүхий л үйл ажиллагаагаа урт хугацааны бодитой судалгаа, тооцоо, менежментийн төлөвлөгөөнд үндэслэдэг бөгөөд нэг удаагийн хандив, тусламжаас илүүтэйгээр урт хугацааны хөгжлийг чухалчилж, тогтвортой, үр дүнтэй эргэх холбоог хэвшүүлэхийг зорьж байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд төслийн үндсэн үйл ажиллагаа хэрэгждэг тул орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцүүдийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажилладаг.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн. 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОҮИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

Өнөөдөр тус компани нь уул уурхайн салбарын хэмжээнд КНХ хэрэгжүүлэгч шилдэг компанийн нэгээр зүй ёсоор нэрлэгдэж, оролцогч талуудынхаа итгэлийг хүлээн, нийгмийн зөвшөөрлөө ханган, улс орны болон орон нутгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

2008 оноос хойш

Урт хугацаанд хамтран ажиллаж буй


**₮6.0 ИХ НАЯД
ДОТООДЫН
ХУДАЛДАН
АВАЛТ**

**+800
ҮНДЭСНИЙ
ХАНГАН
НИЙЛҮҮЛЭГЧ**



Нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр

УЛСЫН ТӨСӨВТ
ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР



Энержи Ресурс групп компанийн хэмжээнд нийт охин компаниудын төлсөн татвар, хураамжийн дүн багтсан болно.


бүтээгдэхүүн худалдан авах явдал байдаг. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчдэд аль болох шинэ боломжуудыг олгож, хамтран ажиллахыг нэн тэргүүнд зорьдог.

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн хүрээнд гадаад, дотоодын олон аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр хамтран ажиллаж ирсэн. Тайлант онд нийт 247 аж ахуйн нэгжээс 284 тэрбум төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсны 93% нь үндэсний аж ахуйн нэгж, компаниуд байсан. Өмнөговь аймгийн хэмжээнд орон нутгийн 20 аж ахуйн нэгжээс нийт 3.7 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын Топ 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Тодруулбал, 2009-2020 он хүртэлх хугацаанд нийт 1.2 их наяд орчим төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Зөвхөн 2020 онд л гэхэд татвар, шимтгэл хэлбэрээр нийт 190 гаруй тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлжээ. Түүнчлэн шууд ба шууд бусаар нийт 4,000 орчим хүнийг ажлын байраар хангаж, давхардаагүй тоогоор дотоодын 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй идэвхтэй хамтран ажиллаж ирсэн.

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа

НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ



Үндэсний аж ахуйн нэгжүүдээс хийсэн худалдан авалт 93%

Онцлох ажлууд

Тайлант онд “Ковид-19” цар тахлын нөлөөллийн улмаас улс орон даяар амаргүй нөхцөл байдал үүсч, компанийн үйл ажиллагаанд тааварлашгүй сорилт, бэрхшээлүүд олноор тулгарсан хүндхэн үе байсан. Гэсэн хэдий ч нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн засаг захиргаа, малчид, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтай хамтран орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, уламжлалт ажлуудыг аль болох хэвийн хэмжээнд үргэлжлүүлж, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ханган ажиллалаа. 2020 онд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн онцлох ажлуудаас дурьдвал:

- Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг шинэчилсэн байдлаар үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Цогтцэций суманд зөвлөх багш нар, математикийн багшийг Улаанбаатараас гэрээгээр ажиллуулж, нийт багш нарт үр дүнгийн урамшуулал олгож, математикийн цахим программыг нэвтрүүлэн ажилласан. Үүний үр дүнд “Мөрөөдөл” дунд сургууль нь аймагтаа чанараар тэргүүлдэг төдийгүй төгсөгчдийн чанараар улсын дунджаас дээгүүр бичигдэх болсон.
- Орон нутгийн ЖДҮ, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн зээлийн санд 50 сая төгрөгийн санхүүжилт нэмэлтээр байршуулж, Цогтцэций сумаас шинээр 9 иргэнд нийт 70.7 сая төгрөгийн хүүгүй бичил зээл олгон бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мөн уг хөтөлбөрийг цаашид өргөжүүлэх чиглэлээр Цогт-Овоо, Ханхонгор сумдад судалгаа хийж, хамрагдах хүсэлтэй иргэдтэй уулзан, мэдээлэл өгөх, бизнес төсөл боловсруулах сургалтыг орон нутгийн “Амжилтын томъёо” ТББ-тай хамтран зохион байгуулсан.
- Цөлжилт, хөрсний доройтлын эсрэг салхины хаалт байгуулах “Ойн зурвас” төслийн хүрээнд тайлант онд 3.6 га талбайд нийт 40 өрх, 3 байгууллага 20 орчим төрлийн төмс, хүнсний ногоо тариалж 80 тонн ургац хураан авсан. Төсөлд хамрагдаж тариалалт хийсэн Цогтцэций сумын иргэд өрхийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй орон нутгийн зах зээлд борлуулалт хийж, өрхийн амьжиргаагаа дэмждэг.
- Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 3х3 сагсны үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр ажилладаг. Энэ хүрээнд 2020 онд “Энержи 3х3” мэргэжлийн клубыг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулилт, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүдэд оролцох боломжийг бүх талаар бүрдүүлэн ажиллалаа.
- Сонгдо эмнэлэгтэй хамтран “Зүрх мартахгүй” төслийг хэрэгжүүлж, төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдийг хагалгаанд оруулж, эмчилгээний холбогдох зардлыг бүрэн санхүүжүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан орон нутгийн иргэд +8,000

**ОРОН НУТГИЙН
ХУДАЛДАН
АВАЛТ**

₮3.7 тэрбум

2020 он

**ОРОН НУТГИЙГ
ДЭМЖИХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ**

₮8.5 тэрбум

2020 он

ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА БА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг мөрдлөг болгож, хүний эрхийг дээдлэх, оролцогч, сонирхогч талуудын идэвхтэй оролцоог хангах, шударга, нээлттэй, ил тод байх зарчмуудыг баримтлан ажиллахыг эрмэлздэг.

Бид үйл ажиллагаа эхлүүлсэн цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр хамгийн багадаа нэг тэрбум орчим төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсаар ирсэн.

Энэхүү хөтөлбөр, төслийн хүрээнд иргэд, оролцогч талуудтай зөвлөлдөх, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг түгээх, орон нутгийн иргэд, оролцогч талуудаас ирсэн санал гомдлыг барагдуулахад анхааран ажилладаг. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд компанийн орон нутагт оруулсан бүхий л хөрөнгө оруулалт нь тус бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, цаашлаад орон нутгийн иргэд төдийгүй компанид ч үр өгөөжөө өгөх зорилго агуулагдаж байдаг.

Оролцогч, сонирхогч талуудын хамтын ажиллагаа

Энержи Ресурс компани нь төслийн үйл ажиллагаандаа оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн урт хугацаанд тогтвортойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу дараах зарчмуудыг ханган ажилладаг.

- Иргэд, олон нийтийг компанийн үйл ажиллагааны талаар холбогдох мэдээлэл авах эрхийг бүхий л талаар ханган ажиллах;
- Олон нийтийн иргэдийн санал хүсэлтийг “Нээлттэй өдөрлөг” хийх замаар үйл ажиллагаандаа тогтмол тусгах;
- Орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар төрөл бүрийн хэлэлцүүлэг, бүлгийн уулзалт, сайн дурын зөвлөлийг дэмжин ажиллах;
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн, урт хугацааны, зорилтот төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Иргэдийн санал, хүсэлт болон өргөдөл гомдлыг мэдээллийн төв болон бусад сувгаар тогтмол хүлээн авах, мэдээлэл харилцааны хоёр талт урсгалыг хэвшүүлэх;

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл байгуулан тууштай хамтран ажилласаар ирсэн. Энэхүү зөвлөлд сум, орон нутаг дахь нийгмийн бүхий л хэсгийн төлөөллүүдээс багтдаг бөгөөд тэдний идэвхтэй оролцоог хангаж ирсэн.

Түүнчлэн орон нутгийн иргэдийг төслийн талбайн үйл ажиллагаатай нээлттэй танилцуулах болон байгаль орчны мониторингийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлдөг. Тухайлбал 2020 онд 85 иргэн байгаль орчны хяналт, мониторингийн ажилд оролцсон бол уурхайн үйл ажиллагаатай 487 иргэн танилцсан байна.

Өргөдөл, гомдол барагдуулах механизм

Орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж эргэн мэдээлэх журам хэрэгжүүлэн ажилладаг. Ингэхдээ өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг.

2020 онд “Иргэд, хуулийн этгээд, сонирхогч талуудын өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, судлан бүртгэх” журмын хүрээнд мэдээллийн төвөөрөө дамжуулан нийт 55 өргөдөл, хүсэлт хүлээн авч, 30 хоногийн дотор шийдвэрлэсэн. Нийт хүлээн авсан өргөдлүүдээс 4 өргөдөлд татгалзсан хариу өгч, 51 өргөдлийг шийдвэрлэсэн байна. Нийт өргөдлүүдэд компаниас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сургалтад хамрагдах, хамтран ажиллах мөн санхүүгийн болон биет дэмжлэг хүссэн, утгатай хүсэлтүүд зонхилж байсан. Тайлант хугацаанд ноцтой гомдол хүлээж аваагүй. Компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлттэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсний үр дүнд сүүлийн жилүүдэд иргэдийн гомдол, саналын тоо багасч, харин хамтын ажиллагааны санал хүсэлтийн тоо эрс нэмэгдэж байна.

Орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр

Орон нутгийн тогтвортой хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төвөөс алслагдсан бүс болох Өмнөговь аймгийн Цогтцэций сум буюу Ухаа худагийн хөндийд өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Мөн 650 айлын, орон сууцны “Цэций” хороолол, сургууль цэцэрлэгийн “Мөрөөдөл” цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн. Түүнчлэн компанийн худалдан авалтын бодлогоо орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглүүлж, Өмнөговь аймгийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчидтэй гэрээлэн ажиллахыг чухалчлан үздэг. 2020 онд л гэхэд орон нутгийн хэмжээнд 20 гаруй аж ахуйн нэгжээс нийт 3.7 тэрбум төгрөгийн бараа материал, ажил үйлчилгээний худалдан авалт хийжээ.

Тайлант онд нийт 8.5 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр болон орон нутгийн худалдан авалт, хандив тусламжид зарцуулсан байна.

Хүснэгт 3. Орон нутгийн хөрөнгө оруулалт (2020)

	Төгрөг
Орон нутгийн дэд бүтэц (Усан хангамж)	2,711,985,000
Орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүд	316,500,000
Хандив тусламж (Өмнөговь аймаг)	1,748,980,000
Худалдан авалт (Өмнөговь аймаг)	3,700,000,000
Нийт	8,477,465,000

Төсөл, хөтөлбөрүүд

Энержи Ресурс компаниас нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлсээр ирсэн. Үүсэн байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэлх арав гаруй жилийн хугацаанд:

- Орон нутгийн боловсролыг дэмжих
- Орон нутгийн ЖДҮ-ийг дэмжих
- Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- Орон нутгийн соёлын өвийг хамгаалах
- Байгаль орчныг хамгаалах гэсэн үндсэн чиглэлүүдээр нийгмийн хариуцлагын нийт 50 гаруй бие даасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирлээ.

2020 оны хувьд Өмнөговь төдийгүй үндэсний хэмжээний нийгмийн тулгамдсан эмзэг асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмрээ оруулан, холбогдох талуудтай хамтран зорилтот төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажилласан.

Улаанбаатарын утааг бууруулах “Цэвэр агаар” төслийн дэмжигч

Улаанбаатарын утааг бууруулах, түүхий нүүрсний хэрэглээг халж, сайжруулсан шахмал түлшээр бүрэн хангах Засгийн газрын үйлсэд хувь нэмрээ оруулан, шахмал түлшний үндсэн түүхий эд болох баяжуулсан эрчим хүчний нүүрсийг төрийн өмчит “Тавантолгой түлш” компанид 2018 оноос хойш үнэ төлбөргүй нийлүүлж байна.

Энэ ажлын хүрээнд одоогийн байдлаар 1 сая гаруй тонн баяжуулсан эрчим хүчний нүүрс нийлүүлээд байна. Монгол Улсын Засгийн газраас гаргасан судалгаа, мэдээллүүдэд Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшинг сүүлийн хоёр жилд ойролцоогоо 40 хувиар буурсан болохыг онцолжээ.

Зүрхний эмгэгтэй хүүхдүүдэд амьдрал бэлэглэх төсөл

Компаниас Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтарсан “Бяцхан зүрх” төслийг 2018 оноос хэрэгжүүлж, төрөлхийн зүрхний гажигтай, дотооддоо эмчлүүлэх боломжгүй, амьдралын боломж муутай хүүхдүүдийг хилийн чанадад хагалгаанд оруулж, эмчилгээний бүх зардлыг бүрэн дааж ирсэн. Одоогийн байдлаар нийт 40 гаруй хүүхэд уг төсөлд хамрагдан, БНХАУ-ын улсын эмнэлгүүдэд эмчлэгдэн, эдгэрээд байна. 2020 оны хувьд “Ковид 19” цар тахлын улмаас хил хаагдсан хэдий ч төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдэд туслах сайн үйлсийн аянаа үргэлжүүлж, “Сонгдо” эмнэлэгтэй хамтран ажилласан. Тус эмнэлгээс санаачлан хэрэгжүүлж буй “Зүрх мартахгүй” төслийг дэмжин зүрхний төрөлхийн гажигтай 5 хүүхдийн мэс заслын болон эмчилгээний нийт зардлыг бүрэн санхүүжүүлж, амьдрал бэлэглэлээ.

Монгол Улсын 3х3 сагсны үндэсний шигшээ багуудын албан ёсны түнш



Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Энержи Ресурс компани 3х3 сагсны үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр ажиллаж байна. Энэ хүрээнд Монголдоо анх удаа “Энержи 3х3” мэргэжлийн клубыг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулилт, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүдэд оролцох бүх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд одоогоор тус клубт мэргэжлийн 6 баг харьяалагдаж байна. Хамгийн чухал нь, багийн спортоор шинэ залуу тамирчид төрөн гарах, гадаад, дотоодод өрсөлдөх боломжийг өргөжүүлж өгч буй ач холбогдолтой.

“Сайн хөрш” хөтөлбөр

Энержи Ресурс компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг 24 цагийн тог цахилгаанаар найдвартай хангахын зэрэгцээ ойролцоох бусад сумдад тог цахилгааны доголдол үүссэн үед цахилгаан нийлүүлж, сумын иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. 2020 онд л гэхэд 68,700 м3 цэвэршүүлсэн ундны ус болон 7 сая квт цахилгаан эрчим хүч нийлүүлсэн байна. Мөн Даланзадгадын дулааны цахилгаан станц болон ойролцоох сумдыг өвөлжилтийн хэрэгцээний эрчим хүчний нүүрсээр жил бүр үнэ төлбөргүй хангаж ирсэн. Тайланд онд нийт 4,100 тонн угааж баяжуулсан нүүрс, 80,600 тонн түүхий нүүрсийг тус тус нийлүүлжээ. Түүнчлэн сүүлийн арван жилийн турш малчдад өвс, тэжээлийн тусламж үзүүлж ирсэн. 2020 онд нийт 9,000 боодол өвс, 1,800 уут тэжээлийг 400 гаруй малчин өрхүүдэд тараасан. Цогт-Овоо, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор сумдын өвсний фондод тус бүрт нь 500 боодол өвс, 100 уут тэжээлийн дэмжлэг үзүүллээ. Эдгээр ажлууд нь орон нутагт тууштай дэмжлэг үзүүлэх “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд уламжлал болон хэрэгжиж ирсэн.

Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөр

Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг 2013 оноос хойш үе шаттай хэрэгжүүлж, 2019 оноос эхлэн шинэчилсэн хэлбэрээр үргэлжлүүлж байна. Цогтцэций сумын ерөнхий боловсролын хоёр сургуулийн нийт 2,000 гаруй сурагчдыг хамардаг уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатараас чадварлаг багш, зөвлөхүүдийг Цогтцэцийд



гэрээгээр ажиллуулах, хүүхэд бүрт хүртээмжтэй математикийн онлайн хөтөлбөр нэвтрүүлэх, багш нарт гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг ажлууд хийгдэж ирсэн. Үүний ч үр дүнд сүүлийн жилүүдэд “Мөрөөдөл” дунд сургууль нь аймагтаа чанараар тэргүүлдэг төдийгүй төгсөгчдийн чанараар улсын дунджаас дээгүүр бичигдэх болсон. Тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас сургуулиуд карантилж, сурагчид хичээлээ зайнаас болон цахимаар үзэх болсонтой холбогдуулан “Сураад” математикийн онлайн хөтөлбөрөө улам идэвхжүүлж, хүүхэд нэг бүрт хүргэх, давтлага ба багш нараас онлайнаар зөвлөгөө авах цагийг

ойртуулах, Улаанбаатараас математикийн өндөр мэргэжлийн багш нартай холбох ажлуудыг эрчимжүүлж ажиллалаа. Одоогоор тус хөтөлбөрийн “Сураад” математикийн онлайн программд дээрхи сургуулиудын 5-11-р ангийн 650 сурагч хамрагдаж байна.

Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөр

Орон нутгийн ЖДҮ, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг 2012 оноос хойш тууштай хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нутгийн жижиг бизнес

эрхлэгчдэд 10 хүртэлх сая төгрөгийн зээлийг хүүгүй олгож, санхүүжилт ба эрсдлийг компаниас 100% хариуцан ажилладаг. Төслийн хэрэгжилтэнд Хас банк ба орон нутгийн “Амжилтын томьёо” бизнесийн зөвлөх ТББ-тай хамтран ажиллаж байна. 2020 оны хувьд хөтөлбөрийн зээлийн санд 50 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлтээр байршуулж, шинээр Цогтцэций сумын 9 иргэнд нийт 70.7 сая төгрөгийн хүүгүй зээл олгон бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүллээ. Ингэснээр хөтөлбөрт одоогоор нийт 60 орчим зээлдэгч идэвхтэй хамрагдан ажиллаж байна. Түүнчлэн хөтөлбөрийг өргөжүүлэх зорилгоор Ханхонгор, Цогт-Овоо сумдад судалгаа, сургалт зохион байгуулж, иргэдээс бизнесийн төслүүд хүлээн авч сонгон шалгаруулалт хийсэн. Зээлийн эргэн төлөлт хугацаа хэтрэх тохиолдол цөөн удаа гарсныг эс тооцвол хөтөлбөрт хамрагдагч иргэд, аж ахуйн нэгжүүд маань зээлдээ маш хариуцлагатай хандаж, зориулалтын дагуу захиран зарцуулдаг бөгөөд бодит үр дүн харагддаг нь манай хөтөлбөрийн гол давуу тал, ач холбогдол юм.

“Ойн зурвас” төсөл



Цөлжилт, хөрсний доройтлын эсрэг Цогтцэций суманд “Ойн зурвас” салхины хаалт байгуулах төсөл 2011 оноос амжилттай хэрэгжиж байна. Анх 5 га талбайд 300 мод, бут суулгаж эхэлсэн бол өнөөдөр нийт 23 га талбайд нийт 15,000 орчим мод бүхий говийн баян бүрд болон өргөжөөд байна. Мод, бутнуудын амьдралтын хувь 85-аас дээш байгаа нь говь нутагт онцгой амжилт бөгөөд ойн зурвасын голын хэсэгт нутгийн иргэд жил бүр төмс, хүнсний ногоо тариалж байна. Тайлант онд гэхэд л 3.6 га талбайд нийт 40 өрх, 3 байгууллага 20 орчим төрлийн төмс, хүнсний ногоо тариалж 80 тонн ургац хураан авчээ. Төсөлд хамрагдаж

тариалалт хийсэн Цогтцэций сумын иргэд өрхийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй орон нутгийн зах зээлд борлуулалт хийж, өрхийн амьжиргаагаа дэмждэг.

Эрчим хүчний нүүрсний хангалт

Өмнөговь аймаг, ба сум орон нутгийн өвөлжилтийн хэрэгцээнд зориулан жил бүр эрчим хүчний нүүрсээр ханган ажиллаж байна. Тодруулбал, 2009 оноос хойш Даланзадгадын дулааны цахилгаан станц, мөн Цогтцэций, Баян-Овоо, Булган, Хүрмэн, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ханбогд, Цогт-Овоо, Сэврэй, Ханхонгор сумдын эрчим хүч болон албан газруудын хэрэгцээний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсээр ирсэн. 2020 онд дээрх газруудад нийт 1.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий 4,100 тонн угааж баяжуулсан нүүрс, 80,600 тонн түүхий нүүрсийг тус тус үнэ төлбөргүй нийлүүлсэн байна.

Ус хангамж

Бид ус хангамжийн системийнхээ хүрээнд уурхайн болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангахаас гадна Цогтцэций сумыг ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Тодруулбал, говийн хатуулаг ихтэй, шууд унданд хэрэглэхэд тохиромжгүй усыг өөрсдийн зардлаар бүрэн цэвэршүүлж, нийлүүлдэг. Дунджаар жилд 120,000 м3 усыг сумын иргэдэд улсын суурь үнээр нийлүүлж байна. Түүнчлэн Цогтцэций сумын төв, Ажилчдын хотхон, “Цэций” хорооллыг ариутгах татуургын нэгдсэн системд холбосон бөгөөд сумын төвд орчин үеийн, европ стандартын, хоногтоо 1,200 тн бохир ус хүлээж авч цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажиллаж байна. 2020 онд сумын цэвэрлэх байгууламж нь 154,000 м3 ахуйн бохир усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр хүлээн авч цэвэрлэсэн.

Бэлчээрийн усан хангамж



хялбарчилдаг давуу талтай.

Орон нутгийн малчдын хэрэгцээнд үндэслэн бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оноос хойш жил бүр зун, намрын улиралд ус хангамжийн системийн гол шугамаас мал усалгааны зориулалтаар усны гаргалгаа цорго нээж өгсөөр ирсэн. Тайлант онд Цагаан-Овоо багийн малчид болон отрын малчдын хүсэлтээр Ус хангамжийн гүний 6, 10-р худгуудын дэргэд мал усалгааны зориулалттай худгийн хоёр гаргалгааг малчдад нээж өглөө. Ингэснээр нийт 10 орчим өрхийн 6,000 гаруй малын усалгааны хэрэгцээ хангагдаж, малчдын хөдөлмөрийг

Орон нутгийн хандив тусламж

Орон нутаг, оролцогч талуудын сайн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай үед мөнгөн болон эд материалын хандив, тусламжийг үзүүлсээр ирсэн. “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, дэмжих чиглэлээр Сумын Онцгой комисс, Сум дундын эмнэлэгт мөнгөн тусламж болон постны байр, гэрэлтүүлэг, хөдөлгөөнт эргүүлийн машин, хоол хүнс, халдвар хамгааллын эд материал зэргээр хандив, тусламж үзүүллээ. Мөн Өмнөговь аймгийн Онцгой комисс болон Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Цогт-Овоо, Ханхонгор сумдад нийт 3,300 ширхэг түргэвчилсэн оношлуурын тест хандивласан.

АМЖИЛТЫН ТҮҮХ

Цогтцэций сумын иргэн Н.Наранцэцэг хөдөө мал маллаж байгаад 2010 онд сумын төвд нүүж ирсэн. Сумын төвд суурьшаад хэсэг хугацаанд хүнсний ногоо тарьдаг байсан. Улмаар 2018 оноос эсгий боловсруулах технологи судалж эхэлсэн.

2020 онд Энержи Ресурс компанийн Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдан 10 сая төгрөгийн хүүгүй зээл авч, эсгийний цех барьж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авсан. Одоо тус цех тогтмол 5-6 хүнийг ажлын байраар ханган өдөрт дунджаар 20 орчим эсгий хийж, гэрийн дээвэр, туурга оёж байна. Түүнчлэн зөвхөн Цогтцэций төдийгүй Даланзадгад болон бусад сумдаас захиалга авч нийлүүлж, цар тахлын хүндрэлтэй нөхцөлд ч үйл ажиллагаагаа хэвийн, амжилттай үргэлжлүүлж байна.



2020.12.31-ний байдлаар

**3,700 ШУУД
БА ШУУД БУС
АЖЛЫН БАЙР**

**2,094 ҮНДСЭН
АЖИЛТАН**



АЖЛЫН БАЙР

Бодлого, баримтлах зарчим

Энержи Ресурс компани нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны аливаа дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөхийн зэрэгцээ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг дагаж биелүүлдэг.

Компанийн зүгээс нүүрсний зах зээлийн харьцангуй тогтвортой байдалтай уялдуулан ажлын байр нэмэгдүүлэх, тэр дундаа орон нутгийн иргэдийг ажил, орлогоор хангах чиглэлд нэн тэргүүний ач холбогдол өгч, нийгмийн хариуцлагаа өндрөөр ухамсарлан, хэдий 2020 онд хөл хорионы хүндрэлтэй нөхцөл байдал тулгарсан хэдий ч ажиллагсдынхаа ажлын байр, цалин урамшууллыг бүрэн хадгалаад зогсохгүй 300 ажлын байр шинээр бий болгож, шинэ бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчдээр хүрээгээ тэлсэн байна.

2020 оны 12-р сарын эцсийн байдлаар тус компани нийт 2,094 үндсэн ажиллагсадтай ба түүний 36%-ийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна.

Онцлох ажлууд

- “Ковид 19” цар тахлын үед ажлын байр, цалин урамшууллаа бүрэн хадгалж, зайнаас ажиллах уян хатан бодлого нэвтрүүлэн ажилласан.
- Компанидаа 6 сараас дээш хугацаагаар ажиллаж буй 1,600 ажилтнуудыг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан. Судалгааны үр дүнгээс харвал, ажиллагсдын 90 хувь нь эрхэлж буй ажилдаа болон компанидаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна.
- Зайн сургалт нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, ажиллагсдад зориулсан сургалтын хэлбэр, аргачлалыг өөрчилж, шинэчлэн боловсруулсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдын тоо, хэмжээг өмнөх оныхоос 36%-иар нэмэгдүүлсэн.
- Орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрийн хүрээнд тогтвортой ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн нийт 56 ажилтны орон сууц болон хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн.

36%

Өмнөговь аймгийн харъяат ажиллагсад

64%

Бусад ажиллагсад

Ажлын байр, тэгш боломж

Бид хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдынхаа эрхийг дээдэлж, ижил тэгш боломжоор хангахыг зорьдог. Ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа ажил горилогсдын мэргэжил, ур чадварын түвшинг эн тэргүүнд харгалзан үзэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харъяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон зэрэг, дэв зэргээс хамаардаг.


Тайлант онд нийт ажиллагсдын ойролцоогоор 13%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийн 11% нь менежер болон удирдах түвшинд ажиллаж буй нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт юм. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. Орон нутагт ээлжээр ажилладаг эмэгтэй ажиллагсдын байр, орон сууцны нөхцлийг сайжруулах ажлууд байнга хийгдэж ирснээс гадна тайлант оноос эхлэн 0-6 настай хүүхэдтэй эмэгтэй ажиллагсдыг ажлын 5 өдрийн нэг өдөрт гэрээс ажиллах боломжийг бүрдүүлэх гэх мэт шинэ зохицуулалтуудыг Улаанбаатар оффист нэвтрүүлэн ажилласан. Ажиллагсдыг насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 64%-ийг 30-50 хүртэлх насныхан, 30%-ийг 30 хүртэлх насныхан бүрдүүлж байна.

300

Шинээр бий болгосон ажлын байр (2020)

2020 онд хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдын тоо хэмжээ 36%-иар нэмэгдсэнээр нийт 75 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж тогтмол орлоготой байхад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ингэснээр Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нийт ажиллагсдын 4 ба түүнээс дээш хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохицуулалтыг бүрэн ханган ажиллаж байна.

АЖИЛЛАГСДЫН ТОО



Нийгмийн халамж

₮87
тэрбум

Ажиллагсдын
нийгмийн даатгал,
цалин урамшуулал
(2020)

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Бид нийт ажилтнууддаа орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл олгох, даатгал, эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, мөн ажиллагсдын хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллагсдын нийгмийн асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн. Түүнчлэн шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд 2020 оны байдлаар 352 ажилтан бүртгэгджээ. 2020 онд нийт ажиллагсдын нийгмийн даатгал, цалин урамшуулалд 87 тэрбум төгрөг олгосон байна.


Шилжилт хөдөлгөөн

2020 онд шинээр 300 хүнийг ажлын байраар хангасан бөгөөд ингэснээр ажиллагсдын шилжилт хөдөлгөөний сүүлийн нэг жилийн үзүүлэлт 10 орчим хувьтай байна. Хэдийгээр хөдөө орон нутагт чадварлаг боловсон хүчний нөөц туйлын дутмаг байдаг ч ажиллагсдын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байдаг нь компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр хадгалан, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм. Тайлант хугацаанд орон сууцны “Цэций” хороололд 11 ажилтныг, “Уурхайчин” хороололд 46 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан. Тогтвортой ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн нийт 56 ажилтанд орон сууц болон хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байна. Компанийн нийт ажилтнуудын 40% нь тогтвор суурьшилтайгаар 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа нь компанийн зүгээс ажилтнуудаа ижил, тэгж боломжоор хангаж ирсний үр дүн юм.

Сургалт, хөгжил

Компани байгуулагдсан цагаас эхлэн мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Ур чадварын үнэлгээгээс ажиллагсдын ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудын төрлийг тодорхойлдог. Тайлант онд ерөнхий ур чадварын болон нарийн мэргэжлийн нийт 46 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 14,184 ажиллагсдыг хамруулсан байна. Тодруулбал 106,292 хүн/цаг сургалт явагдсан бөгөөд нэг ажилтанд дунджаар 7.5 цагийн сургалт ногдож байна. Давхардсан тоогоор нийт 1,393 эмэгтэй ажиллагсдыг сургалтанд хамруулсан байна. Мөн тайлант хугацаанд “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан цахим сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулж, зайн сургалтын арга зүй, сургалтын материалыг голчлон ашигласан.

СУРГАЛТАНД ХАМРАГДСАН
АЖИЛЛАГСДЫН ТОО



НИЙТ ТАРЬСАН
МОД, БУТ, СӨӨГ
137,200

2009-2020

МОДНУУДЫН
АМЬДРАЛТЫН ХУВЬ
+85%

Нийт ойжуулсан талбай: 23 га

БАЙГАЛЬ ОРЧИН

Бодлого, баримтлах зарчим

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн бүхий л үе шатанд байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, Олон улсын стандартыг даган мөрдөж, үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг.

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н бодлогын хүрээнд олон улсын ISO 14001:2004 “Байгаль орчны удирдлагын тогтолцоо” болон OHSAS 18001:2007 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг. Бид нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц зэрэг гол бүтээн байгуулалтууддаа говийн нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй, ус хамгийн бага ашиглах технологийг ашигладаг.

Онцлох ажлууд

Ухаа худаг уурхайн 2020 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж бууруулах, нөхөн сэргээж ногоон байгууламж байгуулах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, хог хаягдлын менежмент, орчны хяналт шинжилгээ зэрэг чиглэлүүдээр 80 гаруй ажил төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн захиргааны байгууллагын зүгээс хангалттай сайн гэж үнэлсэн.

Байгаль орчны багаас говь нутагт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2009 оноос хойш нийт 130,000 гаруй мод тарьж ургуулснаас 2020 онд 9,000 орчим тарьцыг үржүүлэн бойжуулж 5,000 гаруй мод сөөгний суулгац тарьсан бөгөөд нийт модны амьдралтын хувь 85%-иас дээш байна.



- Тайлант онд усны менежмент, технологийн горимд сайжруулалт хийснээр гүний усны хэрэглээг 21 хувиар бууруулж, үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг 11 орчим хувиар нэмэгдүүлсэн.
- Уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийн конвейроос үүсч буй тоосжилтыг бууруулах зорилгоор өндөр технологийн тоос сорогч төхөөрөмжийг суурилуулсан ба хэмжилтийн үр дүнгээр тухайн байгууламж дахь тоосны концентрацийн хэмжээ эрс буурсан байна.
- Мод үржүүлгийн талбайд Сухай, Заг, Хайлаас, Жигд зэрэг модны 9,000 ширхэг тарьцыг үр

болон мөчрөөр тарьж ургуулав. Мөн Монгол орны улаан номонд орсон нэн ховор Тоорой модыг 1,000 ширхэгийг тарихаар үрээр үржүүлэн ургуулж байна.

- Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ өмнөх оныхоос 6 хувиар нэмэгдсэн.
- Наймант ба Наймдайн хөндийд байрлах гүний усны худгуудыг холбосон 10 кВ-ын 60 км шугамын 700 гаруй тулгууруудад шугамын утасны фаз тус бүрт тусгаарлагч бүрээс хийж гүйцэтгэсэн бөгөөд уг ажлыг гүйцэтгэснээр шувууд агаарын шугамын хөндлөвч дээр сууж болон нисэх үед далавчаар гүйдэл дамжуулагчид хүрч хорогдол гарах эрсдэлийг өндөр хувиар бууруулж байгаа болно.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд хаягдал лаг болон хоолны хаягдал ашиглан бордоо хийх төслийг эхлүүлсэн.

Ус хангамжийн цогц менежмент

Ухаа худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг. Түүнчлэн цахилгаан станцаа говийн нөхцөлд тусгайлан зориулж, усны “О” хэрэглээтэй технологиор барьсан учраас Монгол дахь бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4-5 дахин хэмнэдэг. Говь нутгийн ус нь эрдэсжилт, хатуулаг ихтэй учраас ундны усанд тогтмол хэрэглэх нь тохиромжгүй байдаг. Иймд Энержи Ресурс компани ундны усыг цэнгэгжүүлж, Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажиллагсдын хотхоныг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэржүүлсэн усаар хангасаар ирсэн. 2020 онд нүүрс баяжуулах үйлдвэр, түүний дэргэд байгуулсан хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрт усны менежмент, технологийн горимд сайжруулалт хийснээр үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг 11 орчим хувиар нэмэгдүүлсэн. Мөн ахуйн зориулалтын усны хэрэглээг бууруулах ажлыг дотооддоо зохион байгуулсан бөгөөд энэ хүрээнд ажилчдын хотхон, ажлын байранд ус хэмнэгч хошууг нийт 110 шүршүүрт, усны даралт бууруулагч төхөөрөмжийг нийт 99 цоргонд, эзлэхүүн бууруулагчийг ариун цэврийн өрөөний нийт 68 бочкинд суурилуулсан бөгөөд ахуйн хэрэгцээний усны хэрэглээг бууруулах мэдээллийг нийт ажилтны сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгосон.



Хог хаягдлын менежмент

Ухаа худаг төслийн үйл ажиллагааны явцад үүсэх үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг тодорхойлох, хаягдлыг дахин боловсруулах, ангилах, хог үүсэлтийн хэмжээг хянаж бууруулах зорилгоор хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг үүсгэж, сар бүр анализ хийдэг. Мөн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ “3R+R” системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. 2020 онд тосны хаягдал шүүлтүүрээр 500 гаруй замын шон, төмрийн хаягдлаар хаалга, хашаа, хогийн сав, сандал зэрэг нийт 10 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

2020 онд уурхайн талбайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хатуу хог хаядлын нийт хэмжээ 10,439 м3 байсан бөгөөд хог хаядлын дахин боловсруулалтын хэмжээ 6 хувиар нэмэгдсэн. Түүнчлэн уурхайн туслах үйл ажиллагаанаас үүсдэг хог хаягдлын нэлээдгүй хувийг хоол үйлдвэрлэлээс үүсдэг хүнсний ногооны хальс эзэлдэг бөгөөд органик хог хаягдал ашиглан бордоо хийх нь хог хаягдлын менежментийн хувьд оновчтой нэгэн арга замд тооцогддог.

Тиймээс бид ажилчдын кэмп болон оффисын хоол үйлдвэрлэлээс гарсан ногооны хальс болон, мод үржүүлгийн талбайн хог ургамал зэргийг хольж бордоо хийх ажлыг туршилтаар эхлүүлж 236 кг бордоог гаргаж аваад байна. Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг нийт 17 удаа зохион байгуулж, нийт 6.83 м3 хог хаягдлыг цуглуулж төвлөрсөн цэгт хүргүүлсэн бол сум орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд үндсэн болон гэрээт компанийн 127 хүн оролцож нийт 52 м3 хог хаягдлыг түүж цуглуулан цэвэрлэсэн.

Агаарын чанар

Бид төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт болон агаар бохирдуулагч хийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлдэг. Ухаа худаг уурхайн хүрээнд дуу, шуугианы эх үүсвэр, түвшнийг тогтмол үнэлж хянадаг. Мөн тоосжилтийн нөлөөллийг хянах зорилгоор тоосны хэмжилтийг Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, Цагаан хадан дахь тодорхой цэгүүдэд тогтмол хийсээр ирсэн. Эдгээр цэгүүд дэх тоосны хэмжилтийн дүнгүүд Монгол Улсын холбогдох стандарт хэмжээнүүдээс хэтрээгүй байна. Тайлант хугацаанд компанийн зүгээс нүүрс олборлох явцын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн технологийн замын материалыг улаан шавран материалаар засах, технологийн замыг тогтмол услах, тээвэрлэлтийн хурдыг багасгах, цахилгаан станцын нарийн үнс баригч филтерийг горимын дагуу ажиллуулах, нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн туузан дамжуурга дээр өндөр технологийн тоос цуглуулагч филтер суурилуулах зэргээр ажиллалаа.

Мод үржүүлгийн талбай, орчны тохижилт



Байгаль орчны нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж 2009 оноос эхлэн нөхөн сэргээлт, туршилтын талбайд мод, сөөг үржүүлж бойжуулах, улмаар тэдгээрийг уурхай, сумын төв, кэмп, орон сууцны хороолол болон зам дагуу шилжүүлэн суулгалт хийн ажиллаж байна. Тайлант оны хувьд мод үржүүлгийн талбайд сухайны мөчир 2,000 ш, хайлаас үрээр 1,300 ш, жигдний үрээр 3,800 ш, заг бортогонд 1,000 ш, шар хуйс ба агч 500ш тус тус тарьж бойжуулав. Мөн хаврын тарилтаар 2,533 ш мод сөөгний тарьц суулгац, намрын мод тарилтын үеэр 1,600 ш суулгац бэлтгэж, аймгийн мод үржүүлэгч аж ахуй нэгжээс 1,400

ш мод худалдан авч нийт 5,533 ш мод сөөгний суулгац тарилтанд гаргасан. Мод үржүүлгийн талбайд үржүүлж буй мод сөөгний амьдралтын хувь 82% -аас дээш байна.

Мөн сум ба уурхай хоорондын хатуу хучилттай зам дагуух талбай болон “Цэций” хорооллын ногоон байгууламжинд нөхөн тарилтаар 2,773 ш мод, уурхайн барилга байгууламжуудын гадна талбайд 1,000 ш орчим мод сөөгийг шинээр тарьж ургуулан арчилгаа хамгаалалтыг цаг тухайд нь хийж гүйцэтгэв.

“Тооройн төгөл” төсөл



Цогтцэций суманд байгуулсан “Ойн зурвас” жилээс жилд хүрээгээ тэлж, өнөөдөр 23 га талбай бүхий 15 мянга гаруй мод, сөөгтэй томоохон төгөл болоод байна. Уг талбайг цаашид өргөжүүлэх, модны тоо, төрөл зүйлийг нэмэгдүүлэх зорилготой жил бүр тодорхой хэмжээгээр мод тарьдаг. Энэ хүрээнд говь нутагт нэн ховордсон тооройн бичил төгөл үүсгэх зорилгоор тоорой модыг үрээр тарималжуулах ургуулах туршилт судалгааны ажлыг эхлүүлээд байна. Тайлант онд Баянхонгор аймаг Эхийн голоос тоорой модны үр түүж мод үржүүлэг туршилтын талбайд тарьсан. Тоорой мод нь говь нутгийн хамгийн том модлог ургамал

бөгөөд экологийн тэнцлийг хадгахад онцгой ач холбогдолтой боловч байгалийн нөхцөлд сэргэн ургах чадвар багасаж жил ирэх тусам цөөрч ховордсоор байгаа нэн ховор төрөл зүйлийн мод юм. 2020 онд 1,000 ш тоорой мод үрээр тарьж, намрын тооллогоор 85%-тай ургаж байна. Тарьцууд 1-2 жилийн хугацаанд бүрэн бие гүйцэх үед говийн унаган байгальд нь суулгаж, арчлан ургуулах ажлууд хэрэгжих юм.

Хаягдлын овоолгын нөхөн сэргээлтийн төсөл



Ухаа худаг уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу хийх ажлыг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тайлант онд уурхайн хаягдлын овоолгын налуулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучих биологийн нөхөн сэргээлтийн эхний үе шатны ажлыг 5 га талбайд, шимт хөрсөөр хучсан хэсэгт ургамалжуулалт хийж, биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлыг 1 га талбайд эрх бүхий

мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэв.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл

2009 оноос хойш Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор “Цэций хайрхан” уул болон говийн тодорхой бүсүүдэд өвс тэжээл, мөс тавих ажлыг жил бүр зохион байгуулсаар ирсэн. Тайлант онд Хангинахын амны уулын туруутан амьтдад зориулж 200кг байгалийн хужир давс болон 300кг өвс, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын Баяндалай сумын нутагт хамаарах нутгуудад тусгай хамгаалалтай газрын захиргаатай



хамтран 100 боодол өвс тус тус байршуулав. Мөн Ханхонгор сумын нутаг Их ууланд зэрлэг амьтдад зориулсан нарны зайгаар ажилладаг уст цэгийг байгуулж, хүлээлгэн өгсөн. Энэхүү уст цэг нь уулын туруутан амьтдыг амьдрах орчиндоо тогтвортой нутагших, байгалийн ил задгай усгүй үед харангадаж хоргодохоос хамгаалах өндөр ач холбогдолтой юм.

Мөн Ус хангамжийн системийн Наймант ба Наймдайн хөндийд байрлах гүний усны худгуудыг холбосон 10 кВ-ын 60 км шугамын 700 гаруй тулгууруудад шугамын утасны фаз тус бүрт

хөндлөвчөөс хоёр тийш 80 см урттай тусгаарлагч бүрээс хийж гүйцэтгэсэн бөгөөд уг ажлыг гүйцэтгэснээр шувууд агаарын шугамын хөндлөвч дээр суух болон нисэх үед далавчаар гүйдэл дамжуулагчид хүрч шувууны хорогдол гарах эрсдэлийг өндөр хувиар бууруулж байгаа болно.

Иргэдийн оролцоот хяналт мониторинг



Орон нутгийн иргэдэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулах, байгаль орчны хээрийн хэмжилтэнд иргэдийг оролцуулах, хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд өгөх зорилготой сургалт, танилцуулгын ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн. 2020 онд хамтын оролцоотой орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт орон нутгийн нийт 85 иргэн оролцож хяналт тавьлаа. Оролцсон иргэдэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулж, худгийн усны болон тоосны хэмжилтийг газар дээр нь хийж үзүүлэн, хэмжилтийн бодит үр дүнг болон компанийн байгуулсан ногоон байгууламжийг

танилцуулсан. Ийнхүү хамтын оролцоотой мониторингийн ажлыг тогтмолжуулснаар компани болон орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудын харилцан итгэлцэл нэмэгдэх, бүх оролцогч талууд нэгдсэн ойлголтонд хүрэх чухал ач холбогдолтой юм.



АМЖИЛТЫН ТҮҮХ

Говь нутагт бидний 2011 оноос хойш хэрэгжүүлж буй “Ойн зурвас” төсөл маань 10 жилийн хугацаанд 23 га талбайтай, 12,000 гаруй мод буттай болон өргөжиж, говьд “баянбүрд” байгуулах бүрэн боломжтойг тодоор харуулж байгаа билээ. Ойн зурвас нь цөлжилтийн эсрэг, салхины хаалтын үүрэг гүйцэтгэдэг учир голын зориулалтын талбайд нутгийн иргэд хүнсний ногоо тариалдаг. Уг төсөлд хамрагдан олон жил ногоо тариалж буй 12 иргэн нэгдэн “Ургац” бүлгийг байгуулан хүлэмжийн аж ахуй эрхлэлт, ногооны борлуулалт зэргээ хамтын хүчээр шийдэж, бизнесээ өргөжүүлэн ажиллаж байна. 2020 онд бүлгийн гишүүд хамтран хүсний ногоогоо орон нутгийн зах зээлд амжилттай борлуулснаас гадна ногоо даршилж, нөөцлөх арга техникт суралцсан. Мөн дундаасаа сар бүр хуримтлал бий болгон гишүүдээ дэмжин ажилладаг. Цаашид бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлж албан ёсны бүртгэлтэй хоршоо болгохоор төлөвлөж буй бөгөөд ногооны талбайгаа хагалах техник хэрэгсэл, ногоогоо нөөцлөх зоорь зэрэг нэн тэргүүний асуудлуудаа хамтын хүчээр шийдэх боломжтой юм.

Ослын давтамж буурав



**МЭРГЭЖЛЭЭС
ШАЛТГААЛАХ
ӨВЧЛӨЛ
“0”**

**ХАБ-ЫН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН
ҮНЭЛГЭЭ
+90%**

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Бодлого, баримтлах зарчим

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал үнэт зүйл гэж бид үздэг тул хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг нэн тэргүүнд анхаардаг. Бидний зорилго бол мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулах явдал юм.

Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажиллагсдаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн хангахыг эрмэлздэг.


Ухаа худаг төслийн хүрээнд олон улсын ‘ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоо’ болон ‘OHSAS 18001:2008 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага удирдлагын тогтолцоо’ стандартуудын шаардлагын дагуу БОХАБЭА-н удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэн Магадлан -2 аудитаар баталгаажуулан ажиллаж байна.

Энержи Ресурс компани нь Ухаа худаг уурхайн үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийт, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний ач холбогдол өгч “Аюулгүй эхэлж, аюулгүй дуусгая” уриаг эрхэмлэн ажиллаж ирсэн.

Онцлох үзүүлэлтүүд

- Өмнөговь аймаг болон Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалтаар манай үйл ажиллагаа эрсдэл үүсэх магадлал “Бага” буюу 91-ээс дээш хувийн үнэлгээтэй тус тус шалгагдсан.
- 2020 онд Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамж (ХЧТАД)-ийн үзүүлэлт 0.55 байсан нь 2019 оны үзүүлэлтээс 17 хувь буурсан. Нийт гэмтлийн давтамжийн үзүүлэлт 1.64 буюу 2019 оны 2.64-өөс 38 хувь буурсан байна.
- “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Компанийн аюулгүй ажиллагааны сургалтын систем, арга зүйг шинэчилж, цахимд суурилсан сургалтын шинэ төрлийн хувилбаруудыг боловсруулсан.
- Ажиллагсдын урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгийн үр дүнд үндэслэн мэргэжлээс шалтгаалах эрсдлийн ангиллыг илүү нарийвчилж тодорхойлж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамж (LTIFR) & Нийт гэмтлийн давтамж (TRIFR)



Хөдөлмөрийн аюулгүй байдлын үзүүлэлт

2020 онд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийн ажиллагсад 9.1 сая хүн/цаг ажилласан тоон үзүүлэлттэй харьцуулахад ХЧТАД 0.55, мөн нийт гэмтлийн давтамж 1.64 байлаа. ХАБ-ын манлайллын хөтөлбөр 5А, 5М, SMART.TL хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсний үр дүнд ХЧТАД 0.55 нэгжтэй гарсан нь өмнөх оныхоос 17%-аар буурсан үзүүлэлт юм. Тайлант онд мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тохиолдол “0” бүртгэгдсэн. Харамсалтай нь уурхайн талбайн гадна хүний амь эрсэдсэн ноцтой ослын 2 тохиолдол гарсан бөгөөд шуурхай арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж, энэ төрлийн аюулаас урьдчилан сэргийлэх ослын үнэлгээ хийсэн.

Эрүүл ахуйн нөхцөл, хяналт шалгалт

Ажлын байруудад эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэж, эрүүл мэндийн их эрсдэл болон түүнд өртөж буй бүлгийг тодорхойлж, эрсдлийг бууруулах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлдэг. Тогтмол хийгддэг ажлын байрны хэмжилт, мониторингийн дүн эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангаж байгааг илэрхийлж байна.

Тайлант онд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас гурван удаагийн шалгалт хийгдсэн. Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газраас жил бүр хийдэг төлөвлөгөөт шалгалтаар манай үйл ажиллагаа эрсдэл үүсэх магадлал “Бага” буюу 91-100 хувь, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газраас хийгдсэн шалгалтаар мөн эрсдэл үүсэх магадлал “Бага” буюу 95-100 хувийн үнэлгээтэй тус тус шалгагдлаа. Мөн Хүний Эрхийн Үндэсний Комиссоос манай үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн бөгөөд эрсдэл үүсэх магадлал “Бага” буюу 100 хувийн үнэлгээ авсан болно.

Сургалт

Тайлант хугацаанд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид болон зочид гэх мэт нийт 12,900 хүнд хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлийн тусгай материал танилцуулах сургалтыг хүргэж, үүнд нийт 102,271 хүн/цаг зарцуулсан байна. 2020 онд “Ковид-19”-тэй холбоотойгоор сургалтын систем, арга зүйг цогцоор нь шинэчилж, зайны болон цахим сургалтын хэлбэрт шилжсэн. Нийт ажиллагсад болон гэрээт ба туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд зориулсан аюулгүй ажиллагааны бүх заавар, зааварчилгааг компанийн хэмжээнд танилцуулж, цахим сургалтын шинэ платформуудыг боловсруулсан.

“КОВИД-19” цар тахлаас урьдчилан сэргийлэлт

Манай улсад 2020 оны 11 сарын 11-ний өдөр “Ковид-19” цар тахлын дотоодын халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш цар тахлын үед ажиллах эрсдлийн үнэлгээг хийж, компанийн дүрэм, журамд холбогдох өөрчлөлтийг хийж, шинэ журам боловсруулан мөрдөн ажиллаж эхэлсэн. Ухаа худаг уурхайн хэмжээнд Гамшгаас хамгаалах штаб байгуулан эрсдлийн цогц менежмент төлөвлөгөөг боловсруулан, нийт ажиллагсдад мөрдүүлэн ажиллаж байна. Халдвар хамгааллын дэглэмийг эрчимжүүлэх ажлын хүрээнд түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд

нийт ажилтнуудыг хамруулан, хяналтыг тогтмолжуулж, шинжилгээг үе шаттайгаар зохион байгуулан 7,304 удаагийн шинжилгээ хийжээ. Экспортын тээврийн жолооч нарт түргэвчилсэн оношлуурын шинжилгээг долоо хоног тутамд, нийт ажиллагсдад тогтмол давтамжтайгаар зохион байгуулан ажилласан. Нийт ажиллагсад өдөр тутмын хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдаж, зайнаас халуун хэмжилт, цаг тутмын ариутгал халдваргүйжүүлэлт, хүн хоорондын зай барилт, зөвлөмж мэдээллийг тогтмол мөрдүүлэн хэвшүүлсэн.

ISO стандартууд баталгаажуулах магадлан аудит

Ухаа худаг нь Монголоос анх удаа ISO стандартуудаар Олон улсын менежментийн нэгдсэн тогтолцоог цогцоор нь нэвтрүүлсэн. Стандартуудын хэрэгжилтийг тогтмол хянаж, магадлаж явах шаардлагатай байдаг. Тайлант онд Менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хянах магадлангийн хоёр дахь шатны аудитыг “Монсертф” ХХК-ийн аудиторудаар баталгаажууллаа. Уул уурхайн салбарт олон улсын ISO стандартууд цогцоор нэвтэрснээр үйлдвэрлэлийн бүтээмж, чанар сайжрах бөгөөд хариуцлагатай уул уурхай төлөвших гол ач холбогдолтой юм.

Онцгой байдлын бүсийн тусламж, үйлчилгээ

Цогтцэций сумын Онцгой байдлын албатай байгуулсан “Онцгой байдлын үед хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд шаардлагатай үед онцгой байдлын бүсэд тусламж үйлчилгээ үзүүлэн хамтран ажилласаар ирсэн. Цогтцэций сумын Аврах, гал унтраах 44-р анги болон компанийн аврах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор хамтарсан дадлага, сургалт хийж туршлага солилцсон. Тайлант хугацаанд сумын хэмжээнд гарсан гал түймэр, осол аваар, байгалийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, байгууллага, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг аврах хамгаалахад тухай бүр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.

ШАГНАЛУУД

Оны онцлох аж ахуйн нэгж

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй шилдэг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран жил бүр шалгаруулан, шилдгийн шилдгээр өргөмжилдөг. 2020 оны шалгаруулалтад Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн эхний 5-д дахин эрэмбэлэгдэж, уул уурхайн салбар дахь хувийн хэвшлийн тэргүүлэгч аж ахуйн нэгжийн байр сууриа бататгалаа. Онцлох аж ахуйн нэгжийг эрэмбэлэхдээ компаниудын тухайн жилийн орлого, улсын төсөвт оруулсан

татвар, ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ, нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо гэсэн үндсэн үзүүлэлтийг харгалзан үздэг. Энержи Ресурс компанийн хувьд ес дэхь жилдээ уг шалгаруулалтын ТОП 5-д багтсан амжилтыг үзүүлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны талархал

Монгол Улсад Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 98 жилийн ойг тохиолдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Энержи Ресурс компанид талархал олгосон. Коронавирусын халдварт цар тахалтай, эдийн засгийн хүндрэлтэй байгаа үед үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд үр дүнтэй тасралтгүй явуулж, улс орныхоо эдийн засгийг дэмжин нийгмийн хариуцлагын хүрээнд хандив тусламж үзүүлэн ажиллаж байгаад талархал илэрхийлж буйгаа тус яамнаас онцолж, энэхүү талархлыг олгосон.

Өмнөговь аймгийн нэрэмжит хүндэтгэлийн цом, талархал

Өмнөговь аймаг сүүлийн гурван жил дараалан үйл ажиллагаараа улсын хэмжээнд тэргүүлж “Монгол Улсын шилдэг аймаг” -аар шалгарсан.

Тус аймгийг “Монгол Улсын шилдэг аймаг”-аар шалгарахад үнэтэй хувь нэмэр оруулж, хамтран ажилласанд хүндэтгэл үзүүлж, аймаг, орон нутгийн удирдлагуудын зүгээс Ухаа худаг уурхайн хамт олонд хүндэтгэлийн цом, талархал болон тугийг гардуулан өгсөн.

Хаяг: Централ тауэр, 16 давхар
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот 14200
Монгол Улс

Утас: +(976) 7012-2279, 7013-2279
Факс: +(976) 11-322279
Цахим шуудан: contact@mmc.mn
Цахим хаяг: www.energyresources.mn

Ухаа худаг, Уурхайчдын хотхон
Цогтцэций сум
Өмнөговь аймаг 46040
Монгол Улс
Утас: +(976) 7712-2304